

Монголын арьс өнгөний эмч нарын хурлаар хэлэлцэгдэн батлагдсан.

МОНГОЛЫН АРЬС ӨНГӨНИЙ ЭМЧ НАРЫН НИЙГЭМЛЭГИЙН ДҮРЭМ

Улаанбаатар

2000 он

МОНГОЛЫН АРЬС ӨНГӨНИЙ ЭМЧ НАРЫН НИЙГЭМЛЭГИЙН ДҮРЭМ (МАӨЭНН)

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэг нь анагаах ухааны дээд боловсролтой болон гоо засалчид, аль ч мэргэжлийн багш, инженер, эдийн засагч, арьс өнгөний эмч нарыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн олон нийтийн байгууллага болно.

Зорилт нь: *Гишүүдийнхээ мэдлэг дадлага бүтээлч үйл ажиллагааг дээшлүүлж тэдний мэргэжлийн эрхийг хамгаалах замаар өөрийн оронд анагаах ухаан, эрүүлийн хамгаалахыг хөгжүүлэх, ард олны эрүүл мэндийг сайжруулахад оршино.*

2. Тус нийгэмлэг нь дээр дурьдсан зорилтыг хэрэгжүүлэхдээ эмч нарын Их бага хурал, эрдэм шинжилгээ-практикийн бага хурал, симпозиум семинар, үзүүлэх сургууль, бүтээлийн тайёан үзэсгэлэн зохиох, туршлага нэвтрүүлэх, эмчийн ёс зүйн хүмүүжил, нийгэмлэгийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар ном товхимол, лекц, мэдээллийн материал гаргах, өндөр мэргэжлийн эмч, эрдэмтэд, гоо засалчдын явуулын буюу байнгын бригад ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Олон улсын хурал, зөвлөлгөөн семинар, бусад төрөлжсөн арга хэмжээнд оролцох, өөрийн шугамаар төлөөлөгчид, ажилтныг гадаад оронд зохих журмын дагуу томилох, гадаадын зочид төлөөлөгчдийг урих, хүлээн авах, гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, анагаах ухааны онцлог ач холбогдолтой гадаадын эрдэмтэдийн ном, бусад бүтээлийг орчуулах, хэвлэх тухай өөрийн орны хэвлэлийн газарт санал зөвлөгөөн өгөх зэрэг гадаад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Нийгэмлэг нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль болон төр засгийн бусад хууль тогтоомжийн хүрээнд явуулна. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэг нь хуулийн этгээд бөгөөд албан бичгийн хэвлэмэл хуудас тэмдэг хэрэглэнэ.

4. Нийгэмлэг нь МУ-ын эрүүл мэндийн яам, олон нийтийн байгууллагууд, эмнэлгийн болон бусад байгууллагын хүмүүсээс сайн дурын үндсэн дээр байгуулсан нийгэмлэг, эсвэл холбоотой ажиллагаагаа зохицуулж хамтран ажиллана.

5. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн үүрэг:

- a) Нийгэмлэгийн үйл ажиллагааны бодлого ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлж, төсөв санхүү татварын асуудалд хяналт тавина.
- b) Нийгэмлэгийн ажил төрлийн холбогдолтой дүрэм заавар журам боловсруулна.
- c) Практикийн байгууллагад ажиллаж байгаа эмч нараас эрдэм шинжилгээний ажил хийхэд тусалж дэмжлэг үзүүлнэ
- d) Анагаах ухааны шинэхэн ололт, амжилтыг сурталчлах нээлт, шинэ бүтээл гаргах хөдөлгөөнийг өрнүүлж өөрийн орны болон бусад орны анагаах ухааны ололт, туршилтыг эмнэлгийн практикт нэвтрүүлэх.

- е) Арьс өнгөний эмч, гоо засалчдын онолын ба мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, практикийн дадлагыг сайжруулах шаардлагатай үед тэдний мэргэжлийн эрхийг хамгаалах ажил зохионо.
- ф) Эрүүлийг хамгаалах, анагаах ухааны тулгамдсан асуудлыг сонгон авах, шийдвэрлэх арга хэмжээ боловсруулахад МУ-ын Эрүүл мэндийн яаманд тусалж уг ажлыг хэрэгжүүлэхэд эрдэм шинжилгээний болон улс олон нийтийн бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

6. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн эрх:

- а) Нийгэмлэгийн ажлын талаар асуудал боловсруулж, МУ-ын Эрүүл мэндийн яам, бусад байгууллагуудад оруулж шийдвэрлүүлнэ.
- б) Нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож тодорхой үр дүн гаргасан гишүүдийг диплом, баярын бичиг, дурсгалын зүйл, тогтмол хэвлэлийн захиалга, мөнгөн шагналаар шагнах ба Эрүүл мэндийн яам бусад дээд байгууллагын шагналд тодорхойлох.
- в) Анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын онол практикийн тулгамдсан асуудлыг цаг хугацаанд нь шийдвэрлэхэд урт богино хугацааны уралдаан зарлаж дүгнэх, эмч нар (гишүүд)-аас туурвисан онол практикийн чухал ач холбогдолтой бүтээлийг урамшуулан шагнах.
- д) Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэг нь МУ-ын эрүүлийг хамгаалах, анагаах ухааныг хөгжүүлэхэд онцгё гавьяа байгуулсан тус улсын болон гадаад орны эрдэмтэд эмч нар гишүүдийг холбогдох байгууллагуудтай санал тохиролцон Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн хүндэт гишүүн цол олгож, диплом, мөнгөн шагналаар шагнаж болно.

Хоёр. МАӨЭНН-ийн гишүүн түүний эрх, үүрэг.

7. МАӨЭНН-ийн дүрмийг зөвшөөрч нийгэмлэгийн шийдвэрийг биелүүлэхэд идэвхитэй оролцдог хүний эмч бусад ажилтан, ажилчид нийгэмлэгийн гишүүн байна. Нийгэмлэгийн гишүүн нь аль нэг байгууллагад харьяалагдана.

Түүний эрх:

А. мэргэжлийн мэдлэг дадлагаа дээшлүүлэх талаар дэмжлэг туслалцаа авах.

Б. эрдэм шинжилгээний ажлын сэдэв сонгох, судалгааны үр дүнг хэвлүүлэх, хэлэлцүүлж зөвлөгөө үнэлгээ дэмжлэг авах.

В. аливаа шагналд нээлт, бүтээлээ дэвшүүлэх, эрдмийн ба мэргэжлийн зэрэг цол хамгаалах хүртэл асуудлаар нийгэмлэгийн дэмжлэг авах.

Г. мэргэжилтэй холбогдсон асуудлаар эрх ашгаа хамгаалуулах.

Д. нийгэмлэгийн удирдах байгууллагуудад сонгох, сонгогдох сонгуульд нэрээ дэвшүүлэх, татгалзах

Е. нийгэмлэгийн аль ч шатны байгууллагын бодлого боловсруулах, хэлэлцэхэд санал санаачлага гаргах, биечлэн оролцох.

Гишүүний үүрэг:

А. нийгэмлэгийн дүрэм бодлого шийдвэрийг биелүүлэхийн төлөө идэвхитүй үйл ажиллагаа явуулах.

Б.сургалт бие даалтын хэлбэрүүдийг оновчтой ашиглан мэргэжлийн мэдлэг дадлагаа байнга дээшлүүлэх.

В. эрхэлсэн мэргэжил, ажилдаа дүн шинжилгээ хийж байхын зэрэгцээ шинжлэх ухаан туршлага нэвтрүүлэх талаар идэвхитэй ажиллах.

Г.хүн амын дунд эрүүл ахуй, эрүүлийг хамгаалах, анагаах ухааны ололт амжилтыг өргөн сурталчлах.

Д.монгол хүний эмчийн ажил мэргэжлийн үндсэн эрх үүрэг, ёс суртахууны хэм хэмжээг чандлан сахина.

Е.гишүүний татварыг тогтоосон журмаар өгч, нийгэмлэгийн сан хөмрөгийг арвижуулахад дэмжлэг үзүүлэх.

8.Хүний эмч, гоо засалчид бусад мэргэжлийн хүмүүс тус нийгэмлэгт хүсэлтээ гаргаж гишүүнээр элсэнэ.

9.Гишүүн нийгэмлэгээс сайн дураар гарах, дахин элсэб асуудлуудыг тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

Гурав. Зохион байгуулалтын бүтэц:

10.Шаардлагатай үед анхан шатны байгууллага ажиллуулж болно.

11.Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн дээд эрхийг барих байгууллага нь бүх гишүүдийн их бага хурал юм. Бага хурлыг 5 жилд 1 удаа бүх гишүүдийн хурлыг жилд 1 удаа хуралдуулна.

12.Удирдах дээд байгууллага нь Их хурал бөгөөд ээлжит их хурлыг 5 жилд 1 удаа хуралдуулна.

Нийгэмлэгийн бүх шатны удирдах байгууллага нь их хурлын хугацаагаар сонгогдоно.

Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн их хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж зохих шийдвэр гаргана. Үүнд:

А.монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн тайлан илтгэл, цаашид тавих зорилт.

Б. Шалган байцаах комиссын тайлан илтгэл

В. Нийгэмлэгийн дүрмийн тухай

Г. Нийгэмлэгийн тэргүүлэгчид шалган байцаах комиссыг сонгох

Д. Анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын тулгамдсан асуудал.

13. нийгэмлэгийн их хурлуудын хооронд МАӨЭНН-ийг төлөөлөн удирдах үүрэг бүхий тэргүүлэгчдийг 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр их хурлаас өдөр дутмын ажлыг удирдах зохицуулах үүрэгтэй МАӨЭНН-ийн дарга, нарийн бичгийн дарга, тэргүүлэгчдийг сонгоно.

14.Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн тэргүүлэгчид нь нийгэмлэгийн зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх, ээлжит болон ээлжит бус их хурлыг зарлан хуралдуулах, их хуралд оролцох Төлөөлөгчдийн тоог тогтоох, сонгох

журмыг батлан гаргах зэрэг үүрэгтэй ажиллах бөгөөд хурлаа 2-3 жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.

15. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн тэргүүлэгчид нь:

А.Нийгэмлэгийн ойрын ба хэтийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах

Б.Нийгэмлэгийн тэргүүлэгчдийн хурлын хугацааг товлож бэлтгэл ба зохион байгуулалтын ажлыг хангах.

В.Хэвлэл мэдээллийн асуудлыг харилцаж орчин үеийн анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын ололт амжилтыг сурталчлах нэвтрүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний цуврал, мэдээлэл, лекц зэргийг хэвлүүлж гишүүдийн хүртээл болгох, эрдэм шинжилгээний бага хурал зөвлөгөөн семинар зохион байгуулах, гишүүдийн шилдэг бүтээлийг шалгаруулан шагнах.

Г.Олон улсын болон гадаад орны эмч нарын нийгэмлэг, байгууллагуудтай харилцаа тогтоож ажил хэрэгчээр хамтран ажиллах зэрэг ажлыг эрхэлнэ.

16. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн шалган байцаах комиссыг нийгэмлэгийн их хурлаар сонгоно. Доорх үүргийг гүйцэтгэнэ.

А.Нийгэмлэгийн дүрэм зааврын биелэлт хөтлөлтийг хянах

Б.Нийгэмлэгийн санхүүгийн байдалд үнэлэлт өгч, татвар хураалт, мөнгө хөрөнгө зарцуулалтын байдлыг шалгаж зааварлана.

Дөрөв.МАӨЭНН-ийн хөрөнгө:

17. Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэг нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

18. Нийгэмлэгийн хөрөнгө нь гишүүдийн татвар болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгэмлэгийн гишүүн **бүр жилд 3000** төгрөгийн татвар хураалгана.

Хөрөнгийн бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгэмлэгийн гишүүн бүр жилд 3000 төгрөгийн татвар хураалгана.

Хөрөнгийн бусад эх үүсвэрт улс олон нийтийн байгууллага, хувь хүнээс өргөсөн хандив, нийгэмлэгийн шугамаар зохион байгуулагдсан аливаа арга хэмжээнээс олсон орлого зэрэг хамаарагдана.

Тав.МАӨЭНН-ийн тогтмол хэвлэл:

19. МАӨЭНН-ийн тогтмол хэвлэл нь “Мэдээлэл” сэтгүүл бөгөөд уг сэтгүүлийг эмнэлгийн хэвлэлийн газартай хамтран гаргана.

Анагаах ухаан, Эрүүлийг хамгаалахын онол практикийн цаг үеийн онцлог асуудлаар болон тэргүүн туршлага шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх зорилгоор цуврал бүтээл, мэдээлэл шинжлэх ухааны тойм, лекц зэргийн хэвлүүлж болно.

Зургаа.Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийг татан буулгах:

20. МАӨЭНН-ийг татан буулгах асуудлыг нийгэмлэгийн их хурлаар шийдвэрлэж, нийгэмлэгийн хөрөнгийг улсын орлого болгоно.